



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Рашаант өрхийн эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
Аудитор: Н.Батжаргал
Утас: 70432545 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
3.1 ЗӨВЛӨМЖ	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ	10

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3081
Email: khovd@audit.gov.mn

2026.03.13 № 438
танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН РАШААНТ ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭНХТУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Рашаант өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь орон нутгийн өмч ашиглан зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр ажиллаж байгаа боловч эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг эрх бүхий этгээдээр батлуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Жаргалант сумын Рашаант өрхийн эрүүл мэндийн төв нь гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 444,102.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас тогтмол зардлын санхүүжилт 24,320.7 мянган төгрөг, төсөл хөтөлбөр болон бусад эх үүсвэрээс 6,451.4 мянга нийт 474,874.1 мянган төгрөгийн мөнгөн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 474,228.0 мянган төгрөгийг зарцуулсан, 9,187.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн Эрүүл мэндийн газар болон Жаргалант сумаас үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

"Рашаант өрх" зарим гүшүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн үүсгэн байгуулагчдын 2025 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн хурлаар гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан, өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 10 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр гишүүнчлэлийг баталж, тогтоол гаргасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	183,818	752,621
1.1.2	Дансны авлага	18,008,889	5,612,403
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		45,487
1.1.6	Бараа материал	29,199,359	22,210,311
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	47,392,066	28,620,822
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		-
1.2.1	Үндсэн хөрөнгө	309,747,275	293,518,251
1.2.2	Биет бус хөрөнгө	17,617,334	17,184,000
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	327,364,609	310,702,251
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	374,756,675	339,323,073
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		-
2.1	Өр төлбөр		-
2.1.1.1	Дансны өглөг	16,603,891	3,395,000
2.1.1.3	Татварын өр	8,096,933	45,096
2.1.1.1.3	Богино хугацаат өр төлбөрийн дүн	24,700,824	3,440,096
2.2	Өр төлбөрийн нийт дүн	24,700,824	3,440,096
2.3	Эздийн өмч	20,277,500	20,277,500
2.3.1	Өмч: - төрийн	16,459,770	16,459,770
2.3.2	- хувийн	3,817,730	3,817,730
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,650,600	19,650,600
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	265,084,100	265,084,100
2.3.9	Хуримтлагдсан ашиг	45,043,651	30,870,776
2.3.11	Эздийн өмчийн дүн	350,055,851	335,882,976
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	374,756,675	339,323,073

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	425,506,338	462,384,709
3	Нийт ашиг (алдагдал)	425,506,338	462,384,709
8	Бусад орлого	37,519,165	14,102,771
10	Ерөнхий ба удирдлагын зардал	475,639,271	490,660,355
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(12,613,768)	(14,172,875)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(12,613,768)	(14,172,875)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	51,129,859	(14,172,875)
27	Орлогын нийт дүн	51,129,859	(14,172,875)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,277,500	19,650,600	265,084,100	45,043,651	350,055,851
3	Залруулсан үлдэгдэл	20,277,500	19,650,600	265,084,100	45,043,651	350,055,851
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,277,500	19,650,600	265,084,100	45,043,651	350,055,851
11	Залруулсан үлдэгдэл	20,277,500	19,650,600	265,084,100	45,043,651	350,055,851
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(14,172,875)	(14,172,875)
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,277,500	19,650,600	265,084,100	30,870,776	335,882,976

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	421,693,156	474,874,078
	ЭМДаатгалын сангаас	62,062,500	82,440,075
	Татаас, санхүүжилтийн орлого	342,684,823	361,661,926
	Бусад мөнгөн орлого	16,945,833	30,772,077
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	412,930,957	472,105,375
	Ажиллагчдад төлсөн	245,478,106	262,700,790
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	63,703,950	86,654,380
	Бараа материал худалдан авахад төлсөн	31,875,505	31,717,476
	Ашиглалтын зардалд төлсөн	1,809,056	2,283,977
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	18,004,000	3,500,000
	Татварын байгууллагад төлсөн	18,510,151	35,062,428
	Бусад мөнгөн зарлага	33,550,189	50,186,324
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,762,199	2,768,703
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,398,000	2,199,900
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,398,000	2,199,900
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,398,000	(2,199,900)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(603,801)	568,803
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	787,619	183,818
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	183,818	752,621

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,351.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 12,101.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг залруулж, баталгаажуулав. Үүнд:

- ✓ Санхүүгийн тайланд үйл ажиллагааны зардлыг дутуу тусгасан 12,101.3 мянган төгрөгийг бүртгүүлэв.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 3,250.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд 3,250.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

3.1 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Анхан шатны баримтын бүрдэл, бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн, сэлбэг хэрэгслийн материалын шаардах хуудас буруу бичигдсэн, дутуу, жолоочийн тооцооны хуудас бичээгүй, шатахууны тооцоо бодоогүй, зарим эмийн зарцуулалтыг хянахад эмчлүүлэгчийн эмийн түүврийн журналын дүнгээс зөрүүтэй байгаа 2,750.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын зарцуулалтын анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлж, дотоод хяналтыг сайжруулан ажиллах

3.1.2 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад эрх бүхий дээд шатны удирдлагын тушаал шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.12-т “Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад олгох улирлын үр дүнгийн нэмэгдлийг дээд шатны байгууллагын удирдлагаар тушаал шийдвэр гаргуулан олгох.

3.1.3 Томилолтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас, тайлан байхгүй, тооцоог бодоогүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Томилолтоор ажилласан ажилтнаас тайлан, илтгэх хуудас авч, томилолтын тооцоог бодож олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Рашаант ӨЭМТ	Санхүүгийн тайланд үйл ажиллагааны зардлыг дутуу тусгасан	1	12,101.3			1	12,101.3	1	12,101.3				
Нийт дүн		1	12,101.3			1	12,101.3	1	12,101.3				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Рашаант ӨЭМТ	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	2,750.0						2,750.0		
	Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад эрх бүхий дээд шатны удирдлагын тушаал шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн нэмэгдэл олгосон	1	-						-		
	Томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас, тайлан байхгүй, тооцоог бодоогүй	1	500.0						500.0		
Нийт дүн		3	3,250.0						3,250.0		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			